



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 05 сарын 12 өдөр

Дугаар А/308

Булган сум

Яаралтай тусламжийн дуудлага мэдээллийг
нэгдсэн дугаарлалтад хүлээн авах бэлтгэл
ажлыг зохион байгуулах ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Засгийн газрын 2025 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн 67 дугаар тогтоолын 3 дугаар зүйлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Яаралтай тусламжийн дуудлага, мэдээллийг нэгдсэн "112" дугаарлалтаар хүлээн авах үйл ажиллагааг "Теле камерын хяналтын дэд төв"-үүдийн үйл ажиллагаатай уялдуулах арга хэмжээ авах бэлтгэл ажлыг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн ахлагч: Б.Одхүү (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга)

Гишүүд: Б.Эрдэнэбилэг (Цагдаагийн газрын дарга, хурандаа)
Н.Хишигдорж (Онцгой байдлын газрын дарга, дэд хурандаа)

Б.Шижирбаатар (Нэгдсэн эмнэлгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Т.Золзаяа (Монголын "Цахилгаан холбоо" ТӨХК-ийн Булган аймаг дахь салбарын дарга)

П.Отгонбаяр (Эрүүл мэндийн газрын Мэдээлэл технологи, зайн оношилгоо хариуцсан мэргэжилтэн)

Нарийн бичгийн дарга: Г.Насантогтох (Аймгийн Засаг даргын Тамгын газрын дэргэдэх Теле камерын хяналтын дэд төвийн дарга)

2. Орон нутагт яаралтай тусламжийн дуудлага, мэдээллийг нэгдсэн "112" дугаарлалтаар хүлээн авах үйл ажиллагааг Теле камерын хяналтын дэд төвүүдийн үйл ажиллагаатай уялдуулах арга хэмжээ авах бэлтгэл ажлыг зохион байгуулж, үр дүнг мэдээлж ажиллахыг ажлын хэсэг (Б.Одхүү)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА Д.ПҮРЭВ-ОЧИР

Булган Ажил 2025 өдөр бүр Doc/2025/Захирамж

6325010436